



## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 06


Улаанбаатар хот

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих сувиллыг сонгон шалгаруулах журам батлах, сувиллын санхүүжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.7 дахь заалт, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсэг, Улсын Их Хурлын байнгын хорооны 2000 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 03 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм” (орон тооны бус)-ийн 1 дүгээр зүйлийн 1.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих сувиллыг сонгон шалгаруулах журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих орны дээд хязгаар, жилд сувилах даатгуулагчийн тоо, нийт ор хоног”-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих сувилалд олгох нэг ор хоногийн зардлын хэмжээг 30000 /гучин мянган/ төгрөгөөр тогтоосугай.
3. Тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар /Д.Зоригт/-т үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба /Г.Батбилэгт/-нд даалгасугай.
5. Тогтоол батлагдсантай холбогдуулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2014 оны “Мэргэжлээс шалтгаалсан өвчтөний сувиллуудын хувьсах зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 18 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Н.НОМТОЙБАЯР

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны 03 сарын 21 -ний өдрийн 06 тоот тогтоолын нэгдүгээр хавсралт

1116125031-н 5284708

## ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛЫН САНГААС САНХҮҮЖИХ СУВИЛЛЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсэгт заасныг үндэслэн сувиллын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, даатгуулагчдад сэргээн засах тусламж, үйлчилгээг тэгш хүртээмжтэй үзүүлэх зорилгоор үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих сувиллыг сонгон шалгаруулах харилцааг зохицуулахад оршино.

1.2. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих сувилал /цаашид сувилал гэх/-ын сонгон шалгаруулалт нь Эрүүл мэндийн тухай, Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хүрээнд явагдана.

1.3. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих орны дээд хязгаар, жилд сувилах даатгуулагчийн тоо, нийт ор хоногийг нийгмийн даатгалын төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална.

1.4. Сувиллын сонгон шалгаруулалт явуулах хугацаа, сувилалд тавигдах шалгуур үзүүлэлт, үнэлэх аргачлалыг нийгмийн даатгалын төв байгууллага тогтооно.

1.5. Сонгон шалгаруулалт явуулах зарыг санал хүлээж авах эцсийн хугацаанаас 30-аас доошгүй хоногийн өмнө олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлж, сонирхогчдыг оролцох тэгш боломжоор хангана.

### Хоёр. Сонгон шалгаруулах комисс байгуулах

2.1. Сувиллыг сонгон шалгаруулах комисс /цаашид комисс гэх/-ын бүрэлдэхүүнийг томилох, хэрэгжилтийг зохион байгуулах чиг үүргийг нийгмийн даатгалын төв байгууллага хэрэгжүүлнэ.

2.2. Комисс нь дарга, нарийн бичгийн даргыг оролцуулан мэргэжлийн хяналтын байгууллагын болон худалдан авах ажиллагаагаар мэргэшсэн төлөөллөөс бүрдсэн 7-9 хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.3. Сонгон шалгаруулалт зохион байгуулах бүрт комиссыг шинээр байгуулна.



#### Гурав. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах

3.1. Уг журмын 2.2-т заасан комиссын нарийн бичгийн дарга нь товлосон хугацаанд сувиллын сонгон шалгаруулалтад оролцогчдоос ирүүлсэн материалыг зохих журмын дагуу бүртгэн хүлээн авч, битүүмжилсэн хэвээр нь сонгон шалгаруулах комисст хүлээлгэн өгч, акт үйлдэн баталгаажуулна.

3.2. Комисс нь сонгон шалгаруулалтыг дараах дэс дарааллаар явуулна.

3.2.1. Сонгон шалгаруулалтад оролцогчдын төлөөллийг байлцуулан ирүүлсэн материал бүрийн битүүмжлэлийг шалган энэхүү журмын 1.4-т заасан бүрдүүлэх баримт бичгийг хангаагүй материалыг буцаах;

3.2.2. Комиссын гишүүд ирүүлсэн материал бүртэй танилцаж, сонгон шалгаруулалтад орох сувилалд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт, үнэлэх аргачлалын дагуу үнэлгээ өгөх;

3.2.3. Сонгон шалгаруулалтыг холбогдох хууль, журмыг баримтлан шуурхай зохион байгуулж, олонхийн саналаар баталсан дүгнэлтийг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх;

3.2.4. Эрх бүхий албан тушаалтан нь комиссын сонгон шалгаруулсан үйл ажиллагаа, гаргасан дүгнэлт нь холбогдох хууль, журамд нийцсэн эсэхийг хянаж, гарсан зөрчлийг арилгуулах бөгөөд үндэслэлгүйгээр өөрчлөхийг хориглоно.

3.2.5. Сонгон шалгаруулалтын дүнг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын албан ёсны цахим хуудсанд байршуулж, нийтэд мэдээлэх;

3.3. Харьяалах орон нутгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс нь нийгмийн даатгалын төв байгууллагын шийдвэрийг үндэслэн сувиллуудтай “Даатгуулагчид сэргээн засах сувиллын тусламж, үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г байгуулан, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.


#### Дөрөв. Бусад зүйл

4.1. Сонгон шалгаруулалтанд оролцогч нь зохих шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад гомдлоо бичгээр гаргана.

4.2. Гомдлыг 14 хоногийн хугацаанд шийдвэрлээгүй, эсхүл гаргасан шийдвэрийг нь эс зөвшөөрвөл оролцогч нь шүүхэд гомдол гаргаж болно.

4.3. Нийгмийн даатгалын байгууллагатай “Даатгуулагчид сэргээн засах сувиллын тусламж, үйлчилгээ үзүүлэх гэрээ” байгуулан тусламж, үйлчилгээ үзүүлж

буй сувиллын үйл ажиллагааны гүйцэтгэлд хийсэн явцын үнэлгээ болон эрх бүхий байгууллагын шалгалтаар ноцтой зөрчил дутагдал илэрсэн, гэрээний хэрэгжилтийг хангалтгүй дүгнүүлсэн тохиолдолд гэрээг цуцалж, уг гэрээг цуцалсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд сонгон шалгаруулалтад оролцох эрхийг түдгэлзүүлэх хүртэл арга хэмжээ авч болно.



4.4. Сонгон шалгаруулалтад тэнцсэн, “Даатгуулагчид сэргээн засах сувиллын тусламж, үйлчилгээ үзүүлэх гэрээ” байгуулан сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа сувилал нь зайлшгүй шаардлагаар гэрээнд тусгагдаагүй нэмэлт тусламж, үйлчилгээ гүйцэтгэх тохиолдолд тухайн үйлчилгээнд нэмэлт гэрээ байгуулна.

4.5. Нийгмийн даатгалын төв байгууллага нь сувиллын үйл ажиллагаа, тусламж, үйлчилгээний чанар, сангийн зарцуулалтад хяналт тавьж ажиллана.

Нийгмийн даатгалын үндэсний  
зөвлөлийн 2017 оны 03 сарын  
21 -ний өдрийн 06 тоот  
тогтоолын хоёрдугаар хавсралт

1116125031 ш. 5284708

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН  
ӨВЧНИЙ ДААТГАЛЫН САНГААС САНХҮҮЖИХ ОРНЫ ДЭЭД  
ХЯЗГААР, ЖИЛД СУВИЛАХ ДААТГУУЛАГЧИЙН ТОО, НИЙТ ОР ХОНОГ

№	Эдийн засгийн бүс	Орны дээд хязгаар	Жилд сувилах даатгуулагчийн тоо	Нэг ор хоногийн зардлын хэмжээ	Дундаж ор хоног	Нийт ор хоног
1	Баруун бүс	8	240	30000	12	2880
2	Хангайн бүс	28	840	30000	12	10080
3	Төвийн бүс	35	1050	30000	12	12600
4	Зүүн бүс	18	540	30000	12	6480
5	Улаанбаатарын бүс	75	2250	30000	12	2700
6	Нийт	164	4920	30000	12	59040